**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 30 өдөр Дугаар А/717 Булган сум

"Ёс зүйтэй, мэдлэг чадвартай, хариуцлагатай
төрийн алба" сарын аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь хэсэг, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XI/03 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр", Аймгийн Засаг даргын 2016 оны "Төрийн захиргааны албан хаагчдын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай А/500 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 11 дүгээр сарыг "Ёс зүйтэй, мэдлэг чадвартай, хариуцлагатай төрийн алба" сарын аян болгон зарласугай.

2."Ёс зүйтэй, мэдлэг чадвартай, хариуцлагатай төрийн алба" аяны удирдамжийг 1 дүгээр, зохион байгуулагдах үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус батлагсугай.

3.Аяныг зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

4.Аянд шаардагдах 22,482,000 (хорин хоёр сая дөрвөн зуун наян хоёр мянга) төгрөгийн 3,000,000 (гурван сая) төгрөгийг "Булган аймгийн төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-өөс, 19,482,000 (арван есөн сая дөрвөн зуун наян хоёр мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/3захирамж

6324011035

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 30-ны/ний өдрийн А/417 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

"ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН ӨДӨР"-ИЙГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАХ "ЁС ЗҮЙТЭЙ, МЭДЛЭГ ЧАДВАРТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА" САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

**Нэг.Зорилго**:Төрийн албаны шинэтгэлийг орон нутагт эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, сэдэлжүүлэх, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, чадавхжуулахад оршино.

**Хоёр.Хугацаа**: 2024 оны 11 дүгээр сарын 01-30-ны өдөр хүртэл үргэлжилнэ

**Гурав.Хамрах хүрээ**:Булган аймагт ажиллаж буй Нутгийн Захиргааны байгууллагын албан хаагчид буюу аймаг сумын Засаг даргын Тамгын газар, агентлагууд.

**Дөрөв.Зохион байгуулагч**: Аймгийн Засаг даргын Тамгын газар,Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөл .

**Тав.Аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа:**

| д/д | Агуулга | Хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|
| 1 | "Ёс зүйтэй, мэдлэг чадвартай, хариуцлагатай төрийн албан хаагч" видео контентын уралдаан. | XI/01-12 | ТАСЗ-ийн Нарийн бичгийн дарга-Ч.Баттуяа<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн<br>Б.Энхмаа -99991295<br>Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба. |
| 2 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын ахмад болон залуу үеийн уулзалт. | XI/08 | ТЗУХ-ийн мэргэжилтэн М.Энхжаргал - 96025507<br>ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Хосбаяр-99322925<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн А.Сарантуяа-95380678 |
| 3 | E-Mongolia ERP систем (DocX-ийн хэрэглээ), Цахим хөгжлийг дэмжих багц хууль, https://www.shilen.gov.mn-ний ойлголт, хэрэглээ, тайлан хэрхэн тайлагнах тухай нэгдсэн сургалт. | XI/-13-ны $10^{00}$-$15^{00}$ цагт | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн Б.Энхмаа -99991295,<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн А.Сарантуяа-95380678<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн М.Энхжаргал - 96025507<br>ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн<br>Э.Хосбаяр- 99322925 |
| 4 | Булган аймгийн Нутгийн Захиргааны болон төрийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын "Анхдагч Булган" урлагийн наадам-2024. | XI/13 | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга М.Батчимэг- 99798949<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн Б.Отгонсувд-99604657 |
| 5 | Спортын олон төрөлт тэмцээн. | XI/15-16 | ЦШ-ын – дарга хурандаа Х.Энхбаяр - 99010062<br>ЦШ-ын офицер Ц.Цэрэнтогтох -99672111<br>ХШҮ-н мэргэжилтэн Б.Насанжаргал- 99792596 |

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугээр сарын 30-ны/ний өдрийн А/392 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

## "ЁС ЗҮЙТЭЙ, МЭДЛЭГ ЧАДВАРТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА" САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ КОНТЕНТЫН УРАЛДААН, СУРГАЛТ, УУЛЗАЛТ, ТЭМЦЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

<table>
<tr><th>д/д</th><th>Зохион байгуулах ажил</th><th>Нэг бүрийн үнэ</th><th>Нийт шаардагдах хөрөнгө</th></tr>
<tr><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td></tr>
<tr><td>1</td><td>Ёс зүйтэй , мэдлэг чадвартай, хариуцлагатай төрийн албан хаагч" видео контентын уралдаан</td><td>1-р байр -700 000 төгрөг<br>2-р байр -500 000 төгрөг<br>3-р байр -300 000 төгрөг<br>Өргөмжлөл-3х5000=15 000 төгрөг</td><td>1 515 000 төгрөг</td></tr>
<tr><td>2</td><td>Төрийн байгууллагуудын албан хаагчдын цахим ур чадварыг нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалт</td><td><table>
<tr><th>Д/д</th><th>Зардлын нэр</th><th>Хүний тоо</th><th>Нэгжийн үнэ /төгрөг/</th><th>Дүн /төгрөг/</th></tr>
<tr><td>1</td><td>Зочид буудал (2 эм 3 эр)</td><td>9 *1 хоног</td><td>5 өрөө *160,000</td><td>900,000</td></tr>
<tr><td>2</td><td>Үдийн завсарлага</td><td>150</td><td>9000</td><td>1,350,000</td></tr>
<tr><td>3</td><td>Өдрийн хоол хоол</td><td>15*1 хоног</td><td>35,000</td><td>525,000</td></tr>
<tr><td>4</td><td>Оройн хоол</td><td>10*1 хоног</td><td>50,000</td><td>500,000</td></tr>
<tr><td>5</td><td>Бусад зардал</td><td>9 хүн</td><td>40,000</td><td>360,000</td></tr>
<tr><td>6</td><td>УБ-Булган, Булган-УБ шатахууны зардал</td><td>Жийп автомашин 2</td><td>100д 15</td><td>700,000</td></tr>
</table></td><td>4 335 000 төгрөг</td></tr>
<tr><td>3</td><td>"Анхдагч Булган" урлагийн наадам</td><td>1-р байр -1*700 000<br>2-р байр – 1* 500 000<br>3-р байр -1*300 000<br>Үзэгчдийн нэрэмжит шагнал-300 000<br>Шилжин явах цом- 200 000<br>Өргөмжлөл- 4х 50 000 = 200 000<br>Шүүгчийн хөлс-100 000*4= 400 000</td><td>2 600 000 төгрөг</td></tr>
<tr><td>4</td><td>Спортын олон төрөл"-т тэмцээн</td><td>Медаль-714 000<br>Өргөмжлөл- 500 000<br>Шагналын - 8 160 000<br>Дартс самбар түрээс- 150 000<br>Шүүгчийн хөлс- өдрийн 100 000*4 шүүгч= 400 000</td><td>9 924 000 төгрөг</td></tr>
<tr><td>5</td><td>Аймгийн Засаг даргын Тамгын газрын ахмад болон залуу үеийн уулзалт.</td><td>Хоол-47хүн*30000=1 410 000<br>Цай – 47 хүн*2000= 94 000<br>Салат , жууш- 47 хүн*16000= 752 000<br>Бусад зардал- 1 452 000</td><td>3 708 000 төгрөг</td></tr>
<tr><td>6</td><td>Сумдын Удирдлагуудын нэгдсэн сургалт</td><td>Цайны зардал – 400 000</td><td>400 000 төгрөг</td></tr>
<tr><td colspan="4">Нийт дүн : 22 482 000 төгрөг</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Төрийн жинхэнэ албан хаагчийн Тангараг өргөх ёслол. | XI/22 ($10^{00}$) | Төрийн албаны Булган аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ч.Баттуяа-99096326<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн М.Энхжаргал-96025507<br>ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Хосбаяр-99322925<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн А.Сарантуяа-95380678 |
| 7 | Сумдын Удирдлагуудын нэгдсэн сургалт. | XI/25 | Хууль эрх зүйн хэлтсийн дарга Б.Одхүү-99227199<br>ТЗУХ-ийн мэргэжилтэн А.Сарантуяа- 95380678<br>ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Хосбаяр-99322925 |
| 8 | Сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарын сургалт . | XI -сард | ТЗУХ-ийн дарга Д.Эрдэнэбилэг- 99185672<br>ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Хосбаяр-99322925 |

**Зургаа.Аяны зохион байгуулалт:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөл аяны хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаа бүрд тусгайлсан хөтөлбөр боловсруулан, биелэлт, зохион байгуулалтыг хариуцан ажиллана.